



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/84

Мандалговь

Гамшгийн эрсдлийг бууруулах ажлыг
шуурхай зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтыг үндэслэн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл 32.1.1, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12-р сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн хэмжээнд 2020 онд зун намартаа бороо хур ороогүйгээс ургамлын гарцад нөлөөлж өвөлжилт, хаваржилт хүндэрсэн тул Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Гамшгийн эрсдлийг бууруулах нөөц" ажлын батлагдсан зардлаас 12,000 (арван хоёр мянга) боодол өвс, 576 шуудай (14,400 кг) тэжээл нийлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулсугай.

2. Өвс, тэжээл татан авах ажлыг хуулийн дагуу, богино хугацаанд шууд гэрээ байгуулан зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

481210425